

# ЗОХИОГЧИЙН ЭРХ

---

AvaTrade нь таныг avatrade.com дахь бүтээгдэхүүн үйлчилгээ, хэрэглүүрүүд, контент, мэдээллүүдээр хангахдаа таатай байх болно. Энэхүү Үйлчилгээний нөхцөл нь мөн зарим нэг бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой чухал мэдээллүүд болон тодруулгыг агуулна.

Та avatrade.com-ийг хэрэглэхдээ энэхүү үйлчилгээний нөхцөлийг дагаж мөрдөх бөгөөд энэхүү Үйлчилгээний нөхцөл нь та болон avatrade.com хоёрын хоорондын заавал дагаж мөрдөх гэрээ юм. Таны avatrade.com-ийг хэрэглэхэр энэхүү Үйлчилгээний нөхцөл болон avatrade.com дахь бусад холбогдох анхааруулга мэдэгдэлийг хүлээн зөвшөөрсөнөөр эхлэнэ. AvaTrade нь уг Үйлчилгээний нөхцөлийг урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчлөн, шинэчлэх эрхтэй. Таны цаашид avatrade.com-п хандах болон хэрэглэх нь энэхүү Үйлчилгээний нөхцөлийн өөрчлөлт, шинэчлэлийг хүлээн зөвшөөрсөнөөр хүчин төгөлдөр болно.

Энэхүү цахим хуудаст хандахдаа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь таны оршин суугаа газрын хууль тогтоомжийг зөрчиж буй эсэхийг шалгана уу. Бид зөвхөн манай үйлчилгээ нь таны оршин суугаа газрын хууль тогтоомжид нийцэж буй үед л таньд үйлчлэх болно.

## 1. AVATRADE.COM ДЭЭРХ МЭДЭЭЛЭЛ

- 1.1. avatrade.com дахь мэдээлэл нь гуравдагч талын түгээн дэлгэрүүлж болох, баттай эх сурвалж хэмээн тооцогдох контент судалгааний мэдээлэл дээр үндэслэнэ. Мэдээллийг бид шалгаж үзэх болон баталгаажуулаагүй үед бүрэн дүүрэн, үнэн зөв, баталгаатай хэмээн үзэхгүй.
- 1.2. AvaTrade нь AvaTrade дээрх мэдээллийн үнэн бодит байдлыг хангахын сацуу хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр өөрчлөгдөн шинэчлэгдэх бөгөөд бие даан хөрөнгө оруулах шийдвэр гаргахад нь туслана. AvaTrade нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа өгч чадахгүй бөгөөд контент болон таны avatrade.com-д хандах боломжгүй байдал, болон avatrade.com-ээр дамжуулан илгээсэн заавар болон мэдэгдэл очоогүй байх, хугацаанаас хойш очсон зэргээс шууд ба шууд бусаар урган гарах аливаа алдагдал болон хохиролыг хариуцахгүй.
- 1.3. avatrade.com дахь бүх контентууд нь нийтлэгдсэн өдрөөс эхлэн үзэж болохоор байх бөгөөд зах зээлийн үйл явдал болон өөр бусад шалтгаанаар цуцлагдаж болно.
- 1.4. avatrade.com дээр харагдаж байгаа мэдээлэл болон рекордогдсон мэдээллүүдийн хоорондын тохиромжгүй болон эсрэгцсэн байдлын үед аль нэг нь давуу эрхтэй байна. AvaTrade нь avatrade.com дээр харагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлаас шалтгаалсан аливаа алдагдал хохирлыг хариуцахгүй.

## 2. ЗОХИОГЧИЙН ЭРХ

- 2.1. avatrade.com, avatrade.com-ээс татаж авч байгаа программ мэдээллүүд, avatrade.com дээр сурталчлагдаж байгаа нэмэлт мэдээллүүд нь олон улсын зохиогчийн эрхийн тухай хуульд захирагдана. avatrade.com-ийг нь зөвхөн эдгээр хуулиудыг шударга дагаж мөрдөсөнөөр ашиглана.
- 2.2. Зохиогчийн эрх эзэмшигчдийн зөвшөөрөлгүйгээр мэдээллийг хуулбарлах, өөрчлөх, түгээн дэлгэрүүлэх болон ашгийн зорилгоор ашиглахыг хориглоно.

## 3. ГУРАВДАГЧ ТАЛЫН ПРОГРАММ

avatrade.com программуудыг татаж авахыг зөвшөөрөх бөгөөд avatrade.com, программыг үйлдвэрлэгч нар программыг татах үед болон avatrade.com-аас татсан программыг ашиглах явцаас үүдэн гарсан аливаа нэгэн алдагдал хохирлыг хариуцахгүй.

## 4. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ БОЛОН ГЭРЭЭНИЙ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэхүү үйлчилгээний нөхцөл нь AvaTrade болон хэрэглэгч нарын гарын үсэг зурсан гэрээнд нэмэлт болон орох бөгөөд энэхүү Үйлчилгээний нөхцөл нь уг гэрээний нөхцөлийг цуцлах болон өөрчлөхгүй.

## 5. ЛИНКНҮҮДИЙН АШИГЛАЛТ

avatrade.com нь бусад талуудын вебсайтуудын линкүүдийг агуулж болох бөгөөд тэдгээр цахим хуудаснууд дахь мэдээллийн бүрэн бүтэн, үнэн зөв байдал болон цахим хуудсан дээрх материалуудыг хянаж, удирдахгүй. Тэдгээр цахим хуудасны линкүүд нь таньд зөвхөн нэмэлт байдлаар өгөгдөж байгаа бөгөөд тэдгээр цахим хуудаснуудын үйл ажиллагаа болон контентуудтай холбоотойгоор AvaTrade ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

## 6. ХАРИУЦЛАГЫН ХЯЗГААР БОЛОН ЭРХЭЭСЭЭ ТАТГАЛЗАХ

Хариуцлагын дээд хэмжээг хуулиар тогтоогоогүй хэдий ч avatrade.com-оор үйлчилгээ авсан болоод түүнээс шууд ба шууд бусаар үүсэх алдагдал буюу хохирлыг AvaTrade

# ЗОХИОГЧИЙН ЭРХ

---

хариуцахгүй. Мөн гуравдагч талд төвөг удахгүй байхыг хүсэе. МӨН AVATRADE ЭДГЭЭР АЛДАГДАЛ ХОХИРЛЫН ТАЛААР ЗӨВЛӨГӨӨ ӨГЧ САНУУЛСАН БАЙСАН Ч ГЭСЭН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХГҮЙ. ХУУЛИАР ШААРДСАНААС БУСАД ТОХИОЛДОЛД AVATRADE-ИЙН ШУУД ЭРХ МЭДЛИЙН ХҮРЭЭНЭЭС ГАДУУР ТАНЬД БОЛОН ӨӨР ХЭН НЭГЭНД ҮҮССЭН АЛДАГДАЛД ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХГҮЙ. AVATRADE-ИЙН ЭРХ МЭДЛИЙН ХҮРЭЭНЭЭС ГАДУУРХ ТОХИОЛДОЛД ГЭДЭГТ ЭЛЕТРОН БОЛОН МЕХАНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ШУГМЫН /ГАР УТАС, КАБЛЬ, ИНТЕРНЕТ / ЭВДРЭЛ, БАТАЛГААГҮЙ ХАНДАЛТ, ВИРУС, ЦАХИМ ХУЛГАЙ, ОПЕРАТОРЫН АЛДАА, БАЙГАЛИЙН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС/ҮЕР, ГАЗАР ХӨДЛӨЛТ, БОЛОН БУСАД/, ГАЛ, ДАЙН ТУЛААН, БОСЛОГО ҮЙМЭЭН, ТЕРРОРИСТ ҮЙЛ АЖИЛЛАГАА, НИЙГМИЙН ТОГТВОРГҮЙ БАЙДАЛ, ХӨДӨЛМӨРИЙН МАРГААН БУСАД ХӨДӨЛМӨР ХИЙХТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУД, ОСОЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗЭРЭГ ОРНО.

## 7. НӨХӨН ТӨЛБӨР

avatrade.com-ыг ашиглаж буй тохиолдолд, таны avatrade.com-г ашиглах болон энэхүү гэрээний нөхцөлийг зөрчисөнтэй холбоотойгоор гарч ирэх алдагдал, хохирол, хариуцлага, төлбөр, зардал /зөвхөн өмгөөлөгчийн төлбөр бус ба бусад төлбөр/ зэргийг хэрэглэгч нөхөн төлөхөө зөвшөөрөх ёстой.